*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АЛТАННАВЧЫН ЧИНЧУЛУУНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. “*НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖЫГ ИРГЭД ДААТГУУЛАГЧДАД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ,СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА , МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТҮГЭЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ,ҮР ДҮНГ ТООЦОХ ТАЙЛАГНАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД*** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Дүүргийн нутаг дэвсгэрт орших төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран өдөрлөг, явуулын үйлчилгээ, бусад арга хэмжээг зохион байгуулах | Өдөрлөг, явуулын үйлчилгээг удирдамжийн дагуу зохион байгуулсан байна. | Дүүргийн 1-34 хороодоор явуулын үйлчилгээ, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, үр дүн гарсан байна. | 1-ээс доошгүй зохион байгуулсан байна. | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, таниулах, төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй шуурхай, нэг цэгээс хүргэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, зохих түвшинд шийдвэрлэх зорилгоор "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг Баянгол дүүргийн 3, 8, 17, 22, 29, 31 дүгээр хороодын байр, амралтын өдөр буюу Бямба, Ням гарагууд, Мөн “Нээлттэй хаалганы өдөрлөг” явуулын үйлчилгээг 2024 оны 06 дугаар сарын 05, 06, 07-ны өдрүүдэд Баянгол дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах, худалдааны төвүүдэд тус тус зохион байгуулж ажиллалаа. Тус өдөрлөгийн үеэр сайн дурын даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөө–103, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар | 2024.01.02 2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл, зөвлөгөө-25, Тэтгэврийн талаар мэдээлэл, зөвлөгөө-98, Тэтгэмжийн талаар мэдээлэл, зөвлөгөө-82, Тахир дутуугийн тэтгэврийн талаар мэдээлэл, зөвлөгөө-30, бусад талаар мэдээлэл, зөвлөгөө-35 нийт 373 иргэд, даатгуулагчдад тус тус хүргэж ажиллалаа.<br>НДЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 04/1819 тоот тушаалын дагуу "Нээлттэй мэдээллийн сар" аяны хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг "Хархорин худалдааны төв", "Байгаль эх цогцолбор"-т тус тус зохион байгуулж сайн дурын даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөө-152, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар мэдээлэл, зөвлөгөө-72, тэтгэврийн талаар мэдээлэл, зөвлөгөө-95, тэтгэмжийн талаар мэдээлэл, зөвлөгөө–112, тахир дутуугийн тэтгэврийн талаар мэдээлэл, зөвлөгөө-72, бусад талаар мэдээлэл, зөвлөгөө - 39 нийт 500 гаруй иргэд, даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан байна. | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2.**<br>Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилах | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн тоо | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон | Олон нийтэд хүргэх шаардлагатай нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээлэл, | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын багц хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилах зорилгоор дараах ажил, арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын хууль тогтоомж, шинэчлэл, үзүүлж буй үйлчилгээ, газрын үйл ажиллагаа, цаг үеийн | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийтийн сүлжээгээр нийт 98 удаагийн сурталчилгаа мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан. | хэвлэлийн хурал болон бусад мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулах боломжийг бүрдүүлнэ. | холбогдолтой мэдээ мэдээллийг газрын албан ёсны Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан 525 удаагийн постер мэдээг нийтлэн иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт түгээж хүргэсэн.<br>Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад газраас нийгмийн даатгалын хууль тогтоомжтой холбоотой ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүрт нь газрын пэйж хуудас болон байцаагч, ажилтнуудын фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт түгээн сурталчилан ажилласан.<br>Нийгмийн даатгалын багц хууль болон газрын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж нийгмийн даатгалын үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлын хүрээнд МҮОНР, UBS телевизүүдээр 6 удаагийн мэдээ бэлтгэн 24 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт сурталчилан ажилласан. | | |
| 3 | **Арга хэмжээ 1.3.**<br>Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | НДЕГ, БГДЗДТГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч | Дээд газраас ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь тайлагнах, хүргүүлэх | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | дүгнэхэд нийт хэрэгжилт 96,9 хувьтай хэрэгжсэн байна | | | | |
| 4 | **Арга хэмжээ 1.4.**<br>Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Нийгмийн даатгалын тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинээр гарсан заавар журам болон нийгмийн даатгалын үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг таниулах зорилгоор **40** удаа сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад давхардсан тоогоор **1250** аж ахуй нэгж, байгууллага хамрагдсан. | Тайлант хугацаанд 10 сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | Тус газар нь 2024 оны 06 дугаар сарын 05, 06, 07-ны өдрүүдэд “Номин” их дэлгүүрийн дотор, гадна талбайд, “Emart” худалдаа үйлчилгээний төвийн дотор,гадна талбайд, “Хар хорин” худалдааны төвийн дотор, гадна талбайд, нийт 3 байршилд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам зөвлөмжийн хэрэгжилтийг танилцуулан тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж ажилласан. НДЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 04/1819 тоот тушаалын дагуу “Нээлттэй мэдээллийн сар” аяны хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулсан. Өдөрлөгийг “Хар Хорин худалдааны төв”, “Байгаль эх цогцолбор”- т тус тус зохион байгуулсан. Нийт 500 гаруй иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлах мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхижүүлэх зорилгоор Баянгол дүүргийн ОСНААУГ | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэглэгчдэд үйлчлэх төв, "Hunnu mebel" ХХК, "Баянгол дүүргийн онцгой байдлын хэлтэс"-ийн хүсэлтийн дагуу сургалт зохион байгуулан ажилласан.<br>“Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” зорилтын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч байгууллагуудын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад 30 ажил олгогчдын нягтлан бодогчдод Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэлийн төслийг даатгуулагчдад танилцуулах, санал өгөх, авлага барагдуулах, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх цахим үйлчилгээг ашиглахад чиглэсэн үр дүнтэй сургалт зохион байгуулагдлаа.<br>2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “АЖИЛ ОЛГОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН” –ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд 400 орчим байгууллагын гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтнүүд хүрэлцэн ирж оролцлоо.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт 11 мянга орчим байгууллага бүртгэлтэй байгаагаас 7 мянга орчим нь идэвхтэй үйл ажиллагаа явуулан 721 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.<br>Нийгмийн даатгалын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн, ажилтан албан хаагчдынхаа нийгмийн баталгааг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангахад онцгой анхаарч, Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтэд бодит хувь нэмэр оруулсан **“ШИЛДЭГ ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ - АЖИЛ ОЛГОГЧ БАЙГУУЛЛАГУУДАА”** шалгаруулж талархал илэрхийллээ.<br>Нийт оролцсон **АЖИЛ ОЛГОГЧ** байгууллагуудын төлөөллүүд болон Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт шимтгэл төлөгч байгууллагууддаа баярлалаа.<br>Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын төлөө хийгдэж буй шинэчлэл бүрийг шуурхай хүргэн мэдээлж ажиллаж байна. | | |
| 5 | **Арга хэмжээ 1.5.**<br>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлын хүрээнд нийт **6** телевиз **2** FM радио **2** вэб сайтад мэдээ мэдээлэл нийтлүүлж, хамтран ажиллаа. Газар хэлтсүүд фэйсбүүк цахим хуудсаараа дамжуулан иргэд даатгуулагчдад хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. | Нийгмийн даатгал төлөхийн ач холбогдол, нийгмийн даатгалын багц хуулийн талаарх өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр сурталчилах ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын багц хууль, шинэчлэл, үзүүлж буй үйлчилгээ, газрын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг газрын албан ёсны фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан давхардсан тоогоор 55 удаагийн постер мэдээг нийтлэн иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт түгээж хүргэсэн.<br>Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад газраас нийгмийн даатгалын багц хуультай холбоотой ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүрт нь газрын пэйж хуудас болон | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талаар **252** гаруй удаагийн постер мэдээллийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад газраас шейр хийх болон шинээр хийж оруулж, **5** удаагийн шууд лайваар зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан нь дүүрэг хороодын цахим хуудсаар түгээгдэж 256,905 хандалт авсан байна. | ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | байцаагч, ажилтнуудын фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн сурталчилан ажилласан.<br>Нийгмийн даатгалын багц хууль болон газрын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж нийгмийн даатгалын үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлын хүрээнд МҮОНР, UBS телевизүүдээр 6 удаагийн мэдээ бэлтгэн 24 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт сурталчилан ажилласан. | | |
| **ХОЁР. "БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1.**<br>Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Хэрэгжилтийн хувиар | "Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил" зорилтот жилийн хүрээнд тус хэлтсээс "Сургалт-Хөгжил, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж салбарын хэмжээнд дэвшүүлсэн зорилтыг | Нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Байцаагч, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр тус газрын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах арга хэмжээг зохион байгуулсан. Мөн газрын нийт албан хаагчдыг эрдэсийн шинжилгээнд хамруулж, эмчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулсан.<br>Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газрын албан хаагчдын 5-17 насны хүүхдүүдийг "Талх чихэр" ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаатай | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх, байцаагч,ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан. | | танилцуулах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээнд оролцсон хүүхдүүдэд гарын бэлэг гардуулан өгсөн.<br>Байцаагч, ажилтнуудыг эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн Пүрэв гарагт нийтийн бие тамираар хичээллэх боломжоор ханган ажиллаж байна мөн Баянгол дүүргийн усан спорт сургалтын төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, байцаагч, ажилтнуудыг хөнгөлөлттэй үнээр хамруулан ажиллаж байна.<br>Баянгол дүүргийн Засаг даргын дэмжлэгээр 1 албан хаагчийг Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамруулсан. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.2.**<br>Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 23 удаагийн сургалтад 968 /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулсан. | Төлөвлөгөөт болон цаг үеийн бүх сургалтууд хийгдэж үр дүн гарсан байна. | Байцаагч ажилтнуудын мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд "Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай", "Ажлын байрны стресс бууруулах ба жендерийн харилцаа", "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх талаар шинээр батлагдсан хууль тогтоомжийн зохицуулалт, "Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага", "Төрийн албаны тухай хууль, төрийн албан | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчийн ёс зүй, харилцаа хандлага", "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийг чадавхижуулах сургалт", "Архив алба хэрэг хөтлөлтийн сургалт", "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад хамрагдах албан хаагчдад зориулсан сургалт", "Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын хууль тогтоомжийн хэрэглээний ур чадварыг дээшлүүлэх сургалт", "Зөрчил шалган шийдвэрлэх албан хаагчдад зориулсан сургалт" сэдвүүдээр сургалт, сурталчилгааг танхимаар зохион байгуулан ажиллалаа. | | |
| ***ГУРАВ. " БАЙГУУЛЛАГЫН БОЛОН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ " ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД*** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн, зохион байгуулан ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх, мөн шинээр нэвтрүүлсэн SICOS программыг нэвтрүүлэхтэй холбоотой НДЕГ-аас Е-док программаар шуудангаар 2, ЕРП 2 өргөдөл гомдол ирсэн байна. Ирсэн журам, заавар чиглэлтэй тухай бүрт танилцан хариуцсан хэлтэс, албан хаагчдад хүргүүлж, ажлын байран дээр мөрдлөг болгон ажилласан. НДЕГ-аас шинээр нэвтрүүлсэн SICOS программтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, аргачлал, чиглэлүүдийг тухай бүрт дагаж мөрдөн, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2024.01.02 2024.12.31 | |
| 2 | **Арга хэмжээ 3.2.** | Хөтөлбөр төлөвлөгөө | Нийгмийн даатгалын | Төлөвлөгөөнд тусгагдсан | 2024 онд Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн сургалт, | 2024.01.02 2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сургалт сурталчилгааны нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах | батлуулсан байна. | ерөнхий газраас ирүүлсэн сургалт, сурталчилгааны чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулж батлуулсан. | ажлыг хэрэгжүүлж төлөвлөгөөг 99 хувьтай биелүүлсэн байна. | сурталчилгааны чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулж батлуулсан. | | |
| 3 | **Арга хэмжээ 3.3.** ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдээс нийтдээ 1562 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 99,6 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, зөрчилд тооцуулахгүй байх | Тайлант хугацаанд нийт 35 албан бичиг, 14 өргөдөл ирснээс 35 албан бичиг, 14 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |

**Дөрөв. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Монгол бичиг сурах | Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад хамрагдаж сертификат авсан байх | | Монгол хэл бичгийн чадвар ахисан байх | Шинээр гарч байгаа болон нэмэлт өөрчлөлт орж буй холбогдох хууль эрхийн акттай тухай бүр танилцаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж мөн монгол бичгийн хичээл бие даан цахимаар суралцаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 2 | **Арга хэмжээ 4.2.** Photoshop программыг сурах | Анхан шатны түвшинд Photoshop программыг эзэмшсэн байх | | Photoshop программыг албан хэрэглээний түвшинд | Ажил үйлчилгээтэй холбоотой үйлдлүүдийг суран, Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасны дагуу богино болон дунд хугацааны | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эзэмшсэн байна | сургалтад цахимаар хамрагдаж, Photoshop программыг албан хэрэглээний түвшингээс ахиулан эзэмшхээр суралцаж байна. | | |
| 3 | **Арга хэмжээ 4.3.** Англи хэл сурах | Цахим сургалтад хамрагдаж B1 түвшинд хүрэх | | Англи хэлний чадвар түвшин ахисан байх | Англи хэлний чадвараа бие даан суралцаж эзэмшиж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 4 | **Арга хэмжээ 4.4.** Магистрын зэрэг хамгаална | Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байх | | Мэргэжлийн зэргээ дээшлүүлнэ | “Бизнесийн удирдлага”-н чиглэлээр магистрын зэргээ амжилттай хамгаалахаар суралцаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
*( Албан тушаал )*

А.Чинчулуун / ……………………… /
*( Нэр, гарын үсэг )*

……… ……………
*( Огноо )*